



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот

Хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын 3.1, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэжюр финанс ББСБ” ХХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргах 18 сарын хугацаатай, жилийн 12 хувийн хүүтэй, нэг бүр нь 125,000,000 /нэг зуун хорин таван сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1 /нэг/ ширхэг хаалттай өрийн бичгийг нэмж бүртгэсүгэй.

2. Хаалттай өрийн бичиг гаргахтай холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Сэжюр финанс ББСБ” ХХК /Т.Тэгшжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

151800000329